



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 650,000.00 (зургаан зуун тавин мянган) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлт 98.33 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул албан даалгаврын биелэлтийг ханган ажиллахыг “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ-ын Гүйцэтгэх захирал (Г.Гансүх)-д үүрэг болгосугай.

2.“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэр газрын захирал (Г.Гансүх)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлж, дотоод хяналтыг сайжруулан, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1.Монгол Улсын шатахууны нөөцийг хадгалах талаар холбогдох төрийн байгууллагад хандаж, шийдвэрлүүлэн, төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.2. Үйлдвэрийн газрын дүрмийн 4.8.3 дахь хэсэгт заасны дагуу бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх техник, эдийн засгийн үзүүлэлт, бизнес төлөвлөгөөний санал боловсруулан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулан, үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх;

2.3. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэж заасныг мөрдлөг болгон ажиллаж, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх;

2.4. Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-нд нийцүүлэн үйлдвэрийн газрын мөнгөн кассын үйл ажиллагааны журам боловсруулж ажиллах;

2.5. Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

3.Тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

